Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилт тавьж ажилласан байна. Үүнд:

- Улс орны тогтвортой хөгжилд нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулж батлуулах, бодлогын удирдамжаар хангах;
- Хууль тогтоомж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын байгаль орчны бүрэлдэхүүн бүлэг, ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын удирдамжаар хангах;
- Байгаль орчны тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн салбар дундын зохицуулалт, олон улсын болон бүс нутгийн түвшинд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын оролцоо, арга хэмжээг төлөвлөх, өргөжүүлэх;
- Нүүрстөрөгч багатай хөгжил, ногоон хөгжлийг дэмжих цэвэр технологи, шинжлэх ухааны ололт, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, менежментийн тэргүүний арга барилыг туршин нэвтрүүлэх бодлого, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 9 дүгээр хавсралт “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”;

- Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол *“Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол *“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”*
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол *“Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын яам санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2020 онд тус газрын худалдан авах ажиллагаанд шалгалт хийж үндсэн 11 чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Байгаль, орчин аялал жуулчлалын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг үндэслэн 45,916,823.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 459,168.2 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгаль, орчин аялал жуулчлалын яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,619,278.1 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын өө байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.0	1.0	0
Авлага	2,023,601.6	1,118,838.9	(904,762.7)
Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	28,876,906.8	26,473,669.7	(2,403,237.1)
Бараа материал	314,085.4	902,944.1	588,858.7
Бусад эргэлтийн хөрөнгө	13,075,948.2	11,795,941.5	(1,280,006.7)
Үндсэн хөрөнгө	4,225,901.9	6,605,771.6	2,379,869.7
Нийт хөрөнгө	48,516,444.9	46,897,166.8	(1,619,278.1)
Өр төлбөр	0	580.3	580.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	48,516,444.9	46,896,586.5	(1,619,858.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	48,516,444.9	46,897,166.8	(1,619,278.1)

Авлага дансны үлдэгдэл 1,118,838.9 мянган төгрөг болж 904,762.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны төсөл хөтөлбөрийн үлдэгдэл 1,712,080.7 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг Сангийн яамнаас авсантай холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 26,473,669.7 мянган төгрөг болж 2,403,237.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд хэрэгжсэн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 9,585,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээний гэрээг дүгнэж, зардлаар тусгасан нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 902,944.1 мянган төгрөг болж 588,858.7 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал дансанд төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө бүртгэснээс шалтгаалжээ.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 11,795,941.5 мянган төгрөг болж 1,280,006.7 мянган төгрөгөөр буурсан нь 1,840,000.0 мянган төгрөгийн агаарын чанарын иж бүрэн харуулын байрыг ашиглагч байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,605,771.6 мянган төгрөг болж 2,379,869.7 мянган төгрөгөөр өссөн нь 1,890,000.0 мянган төгрөгийн хийгээр цэнэглэх зөөврийн станц, 594,909.0 мянган төгрөгийн газын нөөцийн сав орлогод авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 46,896,586.5 мянган төгрөг болж 1,619,858.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний 12,407,720.7 мянган төгрөгийн зардлыг өмнөх үеийн үр дүнд хааж, тайлант онд 10,788,287.0 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгийн өсөлт голлон нөлөөлсөн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13,001,775.4 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар буурсан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор зарим урсгал зардлын санхүүжилтийг түр хойшлуулж зогсоосонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 13,889,750.5 мянган төгрөгөөр буюу 30.2 хувиар өссөн байна. Төсөл, арга хэмжээний зардал 20,104,872.8 мянган төгрөгөөр өссөн, гэр хорооллын иргэдийн шөнийн тарифын хөнгөлөлтөд зориулан 5,851,028.2 мянган төгрөгийн татаас Тавантолгой түлш ХХК-д олгосон зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2020 оны төсвийн төслийг 361,855,102.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг бодитой төлөвлөөгүйгээс төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 275,651,839.2 мянган төгрөгөөр бууруулж 86,203,262.9 мянган төгрөгөөр баталсан мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 1,152,833.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 86,203,262.9 мянган төгрөгийн төсөв баталсныг 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 65,801,099.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 26,764.9 мянган төгрөг, нийт 65,827,864.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 65,827,877.3 мянган төгрөг буюу 76.4 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 13,026,255.4 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 7,024,694.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 2,070,171.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26,937.6 мянга, ЗГНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөцөөс 656,707.6 мянга, дээд шатны төсөв захирагчийн төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээнээс 82,953.8 мянга, нийт 2,836,770.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 4,277.9 мянга, багаж техник хэрэгсэлд 542,449.3 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 563,001.6 мянга, бараа үйлчилгээний зардалд 814,624.5 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 82,920.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 829,497.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 143 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,766,281.9 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг биелүүлж, 36,619.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-		-				
Албан шаардлага	1	1,766,281.9	1	1,766,281.9			100
Зөвлөмж	3	36,619.5	3	36,619.5			90
Нийт дүн	4	1,802,901.4	4	1,802,901.4			92.5

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,253,423.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,008,690.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,139,268.7 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 4,504,651.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 12,600,812.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Гэрээний урьдчилгаа санхүүжилт 487,016.6 мянган төгрөгийн гэрээ дүгнээгүй, үлдэгдэл төлбөр олгогдоогүй байхад зардлаар бүртгэсэн;
2. Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл 1,857,632.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
3. Төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн хүрээнд бий болсон 664,041.4 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авалгүй шууд зардлаар тайлагнасныг тус тус залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 18,244,733.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,139,268.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,504,651.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүгийн тайланд агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний 1,139,268.7 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн Акт тогтоох.

2. Тайлант онд 4,504,651.9 мянган төгрөгийн тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулаагүй нь Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7(в)-д "худалдан авах ажиллагааг цахимаар /tender.gov.mn/ зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороон гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтөд зориулан баталсан төсвийг бүрэн шилжүүлсэн боловч Эрчим хүчний яамны харьяа 14 төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд 2017-2020 онд их хэмжээний авлага хуримтлагдсан тооцоо судалгаа байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо тайлант жилийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулж батлаагүй, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдвэргүй гаргаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 12,600,812.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ажлын тусгай горимоор ажиллаж, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлсний дансдад аудитын горим сорил хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт, төсөвт өртөг, ажлын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийх нь зүйтэй гэж үзэж байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус яамны санхүүгийн тайланд 309,375.2 мянган төгрөгийн он дамжсан авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд өмнөх онуудын 12,291,437.4 мянган төгрөгийн 18 гэрээний хэрэгжих хугацаа хэтэрсэн, гэрээг дүгнэж, тооцоо нийлж баталгаажуулаагүй урьдчилж төлсөн зардлын үлдэгдэлтэй бүртгэлтэй байна.

2.2. Эрсдэл:

Гэрээний зүйл заалт хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгө үрэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид гэрээний зүйл заалтыг мөрдөж, гэрээт ажлыг хугацаанд нь хүлээн авч дүгнэн, тооцоо нийлж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/298/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам		мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	ОББҮХ-ны тайланд 298.5 сая, БОАЖЯ-ны тайланд 10.8 сая төгрөгийн он дамжсан авлага бүртгэлтэй байна.	309,375.2	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
2	Засгийн газрын 2017 оны 199, 2020 оны 115, 211 дүгээр тогтоолуудын дагуу ОББҮХ нь 2020 оны 05 дугаар тогтоолоор гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтөд зориулан 15,851.03 сая төгрөгийн төсөв баталж, ЭХЯ-ны харьяа газруудад бүрэн шилжүүлсэн боловч эрчим хүчний салбарын 14 төрийн өмчит компаниудад 2017-2020 онд 7,319.5 сая төгрөгийн авлага хуримтлагдсан тооцоо судалгаа байна. ОББҮХ тайлант жилийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулж батлаагүй, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдвэргүй байна.	-	Албан шаардлага өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
3	ОББҮХ 4,504.6 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг цахимаар гүйцэтгээгүй байна.	4,504,651.9	Албан шаардлага өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
4	ОББҮХ-ны санхүүгийн тайланд өмнөх онуудын 18 гэрээний 12,291.4 сая төгрөгийн гэрээний хэрэгжих хугацаа хэтэрсэн, дүгнэж, тооцоо нийлээгүй урьдчилж төлсөн зардал бүртгэлтэй байна.	12,291,437.4	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
5	ОББҮХ агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор 2019 оны 8 сард ХАС банканд 1,800.0 сая, ХААН банканд 800.0 сая, Төрийн банканд 400.0 сая, нийт 3,000.0 сая төгрөгийг байршуулсан ба тайлант онд зарцуулагдаагүй үлдсэн хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	1,139,268.7	Төлбөрийн акт тогтоох	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
ДҮН		18,244,733.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 13/А0160056
САГ-2021/298/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүгийн тайланд агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний 1,139,268,700 төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд төвчихгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөөлсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгаль, орчин аялал жуулчлалын яам төслийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1,139,268,700 /нэг тэрбум, нэг зуун гучин есөн сая хоёр зуун жаран найман мянга долоон зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, ерөнхий нягтлан бодогч Г.Гантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 38/АД160056

Улаанбаатар хот

САГ- 2021/298/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тендер шалгаруулалтыг цахимаар гүйцэтгээгүй 4,504,651,870 (дөрвөн тэрбум таван зуун дөрвөн сая зургаан зуун тавин нэгэн мянга найман зуун далан) төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7(в)-д "худалдан авах ажиллагааг цахимаар /tender.gov.mn/ зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг цахимаар /tender.gov.mn/ зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, ерөнхий нягтлан бодогч Д.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. R.

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

A. B.

А.ДАВААДОРЖ

АУДИТОР

C. C.

Ц.ЦЭРЭНХҮҮ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 40/АД160056

Улаанбаатар хот

САТ-2021/233/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020 оны 05 дугаар тогтоолоор гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтөд зориулан баталсан төсөв хөрөнгийг Эрчим хүчний яамны харьяа газруудад бүрэн шилжүүлсэн боловч эрчим хүчний салбарын 14 төрийн өмчит компаниудад 2017-2020 онд их хэмжээний авлага хуримтлагдсан тооцоо судалгаа байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо тайлант жилийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулж батлаагүй, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдвэргүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолын хавсралтын дараах заалтуудтай нийцэхгүй байна.

2.1-д "Агаарын тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан болон нийслэлийн гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ, халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлнэ";

2.2-т "Аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ болон халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлнэ".

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө",

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлж, өмнөх төлбөр тооцоог хийж, актаар баталгаажуулах, цаашид төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл тооцоог хийх ажлыг хэрхэн зохицуулах талаар судалж шийдвэрлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга Б.Алтанзул, ерөнхий нягтлан бодогч н.Бат-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

А.ДАВААДОРЖ

Ц.ЦЭРЭНХҮҮ

[illegible]